



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН ТУШААЛ

2025 оны 10 сарын 10 өдөр

Дугаар 1/150

Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3.1 дэх заалт, 24.6 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.8 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны төсөв батлах тухай 25/106 дугаар тогтоол, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн дугуйн болон явган хүний замын эвдэрлийг шуурхай засварлах ажлын санхүүжилтийг хавсралтаар баталж, уг төсөл арга хэмжээг дүрмээр хүлээсэн чиг үүргийн дагуу гүйцэтгэж, үр дүнг танилцуулж ажиллахыг Хот тохижилтын газар ОНӨААТҮГ (Г.Ууганбаяр)-т үүрэг болгосугай.

2. Тушаалын хавсралтаар батлагдсан төсөл арга хэмжээний хүрээнд гэрээ байгуулж, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Тохижилт хог хаягдлын удирдлагын газар (Г.Билгүүн)-т гүйцэтгэлд захиалагчийн хяналт тавьж ажиллахыг Тохижилт, хог хаягдлын удирдлагын газрын Хот тохижилтын хэлтэс (Б.Даваабаяр)-т үүрэг болгосугай.

3. Хавсралтаар батлагдсан ажилд шаардагдах 500,000,000 (таван зуун сая) төгрөгийг Хот тохижилтын бусад зардлаас гаргаж санхүүжүүлэхийг Ахлах нягтлан бодогч (Б.Халиун)-д зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн удирдлагын газар (Н.Отгонбаяр)-т даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА
Г.БАТЗОРИГ



Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн
А/150 тушаалын хавсралт

НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ГУДАМЖ ЗАМ ТАЛБАЙН ДУГУЙН БОЛОН ЯВГАН ХҮНИЙ
ЗАМЫН ЭВДЭРЛИЙГ ШУУРХАЙ ЗАСВАРЛАХ АЖЛЫН ЗАРДЛЫН ЗАДАРГАА

№	Төсөл арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	Санхүүжих дүн
		Эхлэх	Дуусах		
1	2	3	4	5	6
1	Нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн дугуйн болон явган хүний замын эвдэрлийг шуурхай засварлах ажил	2025	2025	500,000,000	500,000,000
Нийт дүн				500,000,000	500,000,000

॥ श्रीगणेशाय नमः ॥

לש לשון